



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 41

Есөнбулаг сум

“Аваргыг аймагтаа” дэд хөтөлбөрт нэмэлт,  
өөрчлөлт оруулан шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “Ж” заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Аваргыг аймагтаа” аймгийн дэд хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулан хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. “Аваргыг аймагтаа” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсөвт тусган батлуулж, биелэлтийн явц, үр дүнг жилийн эцэст багтаан ИТХ-ын Тэргүүлэгчдэд тайлагнахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.
3. Уг тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 56 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА



Т.ГАНЗОРИГ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
2014 оны 05 дугаар сарын 16-ны  
өдрийн 41 дүгээр тогтоолын  
хавсралт

## “АВАРГЫГ АЙМАГТАА” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Биеийн тамир спортын тухай хуулийн 18-р зүйлийн 18.8 дахь заалтыг хэрэгжүүлэн шигшээ баг /цаашид аймгийн шигшээ баг/ гэх тогтолцооны үйл ажиллагааг нэгдсэн бодлогын хүрээнд явуулах нийтлэг харилцааг зохицуулахад хөтөлбөрийн зорилго оршино. Шигшээ баг нь өсвөр үеийн авъяастай тамирчдыг спортын сургалт, дасгалжуулалтын нэгдсэн хөтөлбөр, бодлогын дагуу системтэй бэлтгэх залгамж чанар бүхий байнгын ажиллагаатай нэгдмэл тогтолцоо мөн.

Биеийн тамир спортод шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэглэл материал заал талбай, танхимын гэрэлтүүлгийг сайжруулах спортын хэрэгслийг өргөжүүлэн нэмэгдүүлж, Олимп, дэлхий, тив улсын аварга шалгаруулах тэмцээнд медальт байранд шалгарсан тамирчдын амжилтыг бодитойгоор үнэлэх, урамшуулан дэмжиж бэлтгэлийг тасралтгүй явуулах нөхцөл боломжоор хангана.

2013 оны судалгаагаар Говь-Алтай аймагт спортын ордон 1, ЕБС болон спорт заал, сургалтын танхим 29, биеийн тамирын гадна талбай 34, биеийн тамираар хичээллэх хэрэгцээ шаардлагыг хангахгүй, стандартын бус, техник, тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангамж муу байгаа нь орон нутагт биеийн тамир, спортын барилга байгууламжийг нэмэгдүүлж, иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцлийг бүрдүүлэх, эдгээр хүчин зүйлүүдийн улмаас орон нутагт биеийн тамир, спортыг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулав.

### ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

2.1. Олимпийн төрлүүдээр өндөр зэрэглэлийн чадварлаг тамирчид бэлтгэх, бэлтгэсэн дасгалжуулагч, орон нутгийн тамирчдыг урамшуулахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг тодорхойлж байна.

2.2.1. Өсвөрийн шигшээ багийг байгуулах.

2.2.2. Амжилт гаргасан тамирчдад шагнал урамшуулал олгох.

2.2.3. Спортын байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх.

2.2.4. Аймагт зохион байгуулагдах биеийн тамир, спортын уралдаан тэмцээний санхүүжилтийг шийдвэрлэх.

## ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Шигшээ баг байгуулах 1 дүгээр зорилтын хүрээнд:

3.1.1 Аймгийн Засаг даргын дэргэд өсвөрийн шигшээ багийг олимпын хөтөлбөрт багтдаг спортын 7 төрлөөр байгуулах /жү-до бөх, чөлөөт бөх, хөнгөн атлетик, шатар, волейбол, сагсан бөмбөг, таеквонда/

3.1.2 Өсвөрийн шигшээ багийн зардлуудыг жил бүр хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд тусган санхүүжүүлэх

3.1.3 Тамирчдын ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр багш нарын сургалт, тамирчдын сургалт, нээлттэй хэлэлцүүлэг, уралдаан тэмцээн зэрэг ажлуудыг зохион байгуулах

3.1.4 Өсвөрийн тамирчдын авьяас чадварыг нээн илрүүлэх судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулах

3.1.5 Шигшээ баг байгуулсан спортын төрлүүдээс УАШ тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулах талаар арга хэмжээ авч ажиллах

3.1.6 Спортын ур чадвар дээшлүүлэх сургалтанд хичээллэж буй тамирчдын дэргэд спортын шинжлэх ухаан судлалын баг байгуулах

3.1.7 Шигшээ багийн бэлтгэл сургуулилт хийхэд шаардагдах нөхцөл хангамжийг бүрдүүлж ажиллах

3.1.8 Сум сургуулийн бүх шатны тамирчдад спортын онол, сэтгэл зүй, хүмүүжил ёс суртахуун, амьдрах ухааны сургалтыг тусгай хөтөлбөрийн дагуу тогтмол явуулах

3.1.9 Их спортын багш дасгалжуулагчдын залгамж халааг бэлдэх, дасгалжуулагчдыг сэлгэж сольж ажиллуулах, материаллаг бааз сууриар хангаж, ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх

3.2 Амжилт гаргасан тамирчдад шагнал урамшуулал олгох 2-р зорилтын хүрээнд:

3.2.1 Олимп, дэлхий, тив, улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилт гаргасан тамирчдыг мөнгөн шагналаар шагнаж урамшуулах

3.2.2 Спортод онцгой амжилт гаргасан тамирчид, багш, дасгалжуулагчдыг шагнаж урамшуулах

3.2.3 Мөнгөн шагнал авах болзол хангасан тамирчин, дасгалжуулагчийн спортын төрлийн холбоо нь олон улсын олимпын хороогоор хүлээн зөвшөөрөгдсөн гишүүн байна

3.2.4 Багийн спортын төрлөөр медаль хүртсэн багийн тамирчин тус бүрт ноогдох мөнгөн шагналын 50 хувьтай тэнцэх шагналыг хувааж олгоно

3.2.5. Тэмцээнд медальт байрт шалгарсныг нотолсон баримт, диплом, гэрчилгээний хуулбар, тэмцээний албан ёсны хурлын тэмдэглэл, тамирчинг шагнуулах хүсэлтийг хавсаргана.

3.3. Спортын байгууллагын материаллаг баазыг нэмэгдүүлэх 3-р зорилтын хүрээнд:

3.3.1. Биеийн тамир спортын байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлэх, материаллаг баазыг нэмэгдүүлэх.

3.3.2. Тамирчдын бэлтгэл сургуулилт хийх заал, танхимын хүрэлцээг нэмэгдүүлэх.

3.3.3. Тамирчдын хувцас хэрэглэл, бэлтгэл сургуулилт хийх техник, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх.

3.4. Биеийн тамир, спортын уралдаан тэмцээнийг санхүүжүүлэх 4-р зорилтын хүрээнд:

3.4.1. Аймаг болон олон улс, улс, бүсийн чанартай тэмцээнийг зохион байгуулах, олон улс, тив, дэлхийн чанартай тэмцээнд оролцоход шаардагдах зардлыг орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангаас дэмжих

#### **ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА**

4.1. Хөтөлбөрийн санхүүжилт дараах эх үүсвэрээр бүрдэнэ.

4.1.1. Улсын болон орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө

4.1.2. Төсөл хөтөлбөрийн хөрөнгө

4.1.3. Гадаад, дотоодын байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хөрөнгө хандив, тусламж

4.1.4. Бусад эх үүсвэр

4.2. Хөтөлбөрийг 2014-2020 он хүртэл 7 жилийн хугацаанд 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

I үе шат 2014-2016 он

II үе шат 2017-2020 он

#### **ТАВ. ХҮРЭХ ҮР ДҮН, УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

5.1. Биеийн тамираар хичээллэх орчин нөхцөл бүрдэж, иргэдийн бие бялдрын хөгжил сайжирч биеийн тамираар хичээллэгч, эрүүл мэндээ бэхжүүлэгч иргэдийн тоо өсөн, нэмэгдэх.

- 5.2. Багш дасгалжуулагчид, боловсон хүчний ур чадвар сайжирна.
- 5.3. Орчин үеийн стандартад нийцсэн спортын цогцолбор, цанын баазтай болж иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх орчин сайжирна.
- 5.4. Олимп, дэлхий, тив, улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчдын тоо өсөн нэмэгдэж, тамирчдын амжилт дээшилнэ.
- 5.5. Хөтөлбөрийг хэргэжүүлэх ажлын төлөвлөгөөг жил бүр Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталж мөрдөнө.
- 5.6. Хөтөлбөрийн хэрэгжилтийг, аймгийн хэмжээнд удирдлага зохицуулалтаар хангах, явц, үр дүнг үнэлэх, хяналт тавих, үйл ажиллагааг аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс хариуцна.
- 5.7. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, тайлагнах, үйл ажиллагааг аймгийн Соёл, спорт, аялал жуулчлалын газар, Эрүүл мэндийн газар, Боловсролын газар, сумдын ЗДТГ, Спортын холбоод, олон нийтийн оролцоонд тулгуурлан зохион байгуулна
- 5.8. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдалд жил бүр хяналт үнэлгээ хийж дүнг аймгийн Засаг даргын зөвлөлд Соёл, спорт аялал жуулчлалыг танилцуулна.

№	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2013 оны байдлаар /%, тоо/	Хүрэх үр дүнгийн үзүүлэлт	
			2016	2020
1	Хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдагсадын хувь	0.36	20	40
2	Биеийн тамираар тогтмол хичээллэгчдийн хувь	14	18	25
3	Биеийн тамир, чийрэгжүүлэлтийн орон тооны арга зүйч	1	10	19
4	Спортоор тогтмол хичээллэгчдийн тоо	16.6	19.6	23.6
5	Спортын цогцолбор	1	2	3
6	Биеийн тамир, спортын заал	28	29	30
7	Биеийн тамир, спортын ил талбай	34	40	42
8	Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх биеийн тамирын хамтлаг	12	18	30
9	Олимпод оролцох тамирчдын тоо	-	2	4
10	Дэлхийн аваргад оролцох тамирчдын тоо	-	4	6
11	Тивийн аваргад оролцох тамирчдын тоо	2	6	9
12	Олимп, дэлхий, тив, ОУ-ын тэмцээнээс хүртэх медалийн тоо	10	15	20
13	Саун, душ	-	2	4

Мөнгөн шагналын хэмжээ /сая, төг/

№	Тэмцээн	Насны ангилал, медаль									Бэлтгэсэн дасгалжуулагчид		
		Насанд хүрэгчид			Залуучууд			Өсвөр үе					
		Алт	мөнгө	Хүрэл	Алт	мөнгө	хүрэл	Алт	мөнгө	хүрэл	Алт	мөнгө	Хүрэл
1	Олимп	50.0	40.0	30.0							30.0	20.0	10.0
2	Дэлхийн аварга	40.0	30.0	20.0	40.0	30.0	20.0	20.0	15.0	10.0	10.0	9.0	8.0
3	Тивийн аварга	25.0	20.0	15.0	20.0	15.0	10.0	10.0	8.0	6.0	5.0	4.0	3.0
4	Улсын аварга	1.0	0.9	0.8	0.7	0.6	0.5	0.5	0.4	0.3	0.2	1.5	0.1

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ӨСВӨРИЙН ШИГШЭЭ БАГИЙН ЗАРДАЛ

/мян.төг/

№	Спортын төрөл	Шаардагдах хэрэглэл материал	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт дүн	
1	Жү-до бөх	Кимона	15	35.0	525.0	
		Бэлтгэлийн хувцас	15	120.0	1800.0	
		Бэлтгэлийн пүүз	15	70.0	1050.0	
		Багшийн урамшуулал	9 сар	150.0	1350.0	
	Уралдаан тэмцээнд оролцуулах	Бензин	400л	1800	720.0	
		Тамирчдын байр	4 өрөө	50.0x7	1400.0	
		Тамирчдын хоол	15	21.0x7	2205.0	
		Витаминжуулалт	15	4x10.0	600.0	
	Дүн					9650.0
	2	Чөлөөт бөх	Чөлөөтийн терико	15	45.0	675.0
Бэлтгэлийн хувцас			15	120.0	1800.0	
Бэлтгэлийн пүүз			15	70.0	1050.0	
Багшийн урамшуулал			9 сар	150.0	1350.0	
Уралдаан тэмцээнд оролцуулах		Бензин	400л	1800	720.0	
		Тамирчдын байр	4 өрөө	50.0x7	1400.0	
		Тамирчдын хоол	15	21.0x7	2205.0	
		Витаминжуулалт	15	4x10.0	600.0	
Дүн					9800.0	
3		Шатар	Шатар	15	35.0	525.0
	Бэлтгэлийн хувцас		15	120.0	1800.0	
	Багшийн урамшуулал		9 сар	150.0	1350.0	
	Уралдаан тэмцээнд	Бензин	400л	1800	720.0	
		Тамирчдын байр	4 өрөө	50.0x7	1400.0	

		Тамирчдын хоол	15	21.0x7	2205.0	
		Витаминжуулалт	15	4x10.0	600.0	
	Дүн				8600.0	
4	Таеквонда	Кимона	15	25.0	375.0	
		Бэлтгэлийн хувцас	15	120.0	1800.0	
		Лап	15	10.0	150.0	
		Багшийн урамшуулал	9 сар	150.0	1350.0	
	Уралдаан тэмцээнд оролцуулах	Бензин	400л	1800	720.0	
		Тамирчдын байр	4 өрөө	50.0x7	1400.0	
		Тамирчдын хоол	15	21.0x7	2205.0	
		Витаминжуулалт	15	4x10.0	600.0	
	Дүн				8600.0	
	5	Хөнгөн атлетик	Бэлтгэлийн хувцас	15	120.0	1800.0
Бэлтгэлийн пүүз			15	70.0	1050.0	
Багшийн урамшуулал			9 сар	150.0	1350.0	
Уралдаан тэмцээнд оролцуулах			Бензин	400л	1800	720.0
Тамирчдын байр		4 өрөө	50.0x7	1400.0		
Тамирчдын хоол		15	21.0x7	2205.0		
Витаминжуулалт		15	4x10.0	600.0		
Дүн				9125.0		
6		Волейбол	Бөмбөг	20ш	45.0	900.0
			Бэлтгэлийн хувцас	15	120.0	1800.0
	Бэлтгэлийн пүүз		15	70.0	1050.0	
	Багшийн урамшуулал		9 сар	150.0	1350.0	
	Уралдаан тэмцээнд оролцуулах	Бензин	400л	1800	720.0	
		Тамирчдын байр	4 өрөө	50.0x7	1400.0	
		Тамирчдын хоол	15	21.0x7	2205.0	
		Витаминжуулалт	15	4x10.0	600.0	
	Дүн				13225.0	
	7	Сагсан бөмбөг	Бөмбөг	20ш	35.0	700.0
Бэлтгэлийн хувцас			15	120.0	1800.0	
Бэлтгэлийн пүүз			15	70.0	1050.0	
Багшийн урамшуулал			9 сар	150.0	1350.0	
Уралдаан тэмцээнд оролцуулах		Бензин	400л	1800	720.0	
		Тамирчдын байр	4 өрөө	50.0x7	1400.0	
		Тамирчдын хоол	15	21.0x7	2205.0	
		Витаминжуулалт	15	4x10.0	600.0	
Дүн				10775.0		
Нийт дүн				69805.0		

Соёл, спорт аялал жуулчлалын газар